

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО, ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГҮЙ ТАЙЛАН

Огноо: 2021.12.28

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	АГГ-2021/12-ШТА-ГА	Шалгагдсан байгууллага:	ХХААХҮЯ, ЭМЯ, МХЕГ, НЭМҮТ, ГЕГ
Аудитын нэр:	ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО, ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮН		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын гуравдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Аудитын менежер Б.Долгорсүрэн Аудитор Ж.Мөнхбилгүүн, Х.Энх-Амгалан, М.Баяртготх

Хоёр. Аудитын үр дүн:

Аудитын зорилго: Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэл

Аудитын хамарсан хүрээ: Аудитад хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааг зохион байгуулан, бүх түвшинд хэрэгжилтийг хангуйж, хяналт тавих, мэдээллээр хангах чиг үүрэгтэй төрийн тусгай болон төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний харьяа хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудал эрхэлсэн байгууллагууд, төр, хувийн өмчийн лабораториуд, хүнсний сүлжээний бүх үе шатанд оролцогч хуулийн этгээд, иргэний аудитад хамаарал бүхий үйл ажиллагааг хамрууллаа.

ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГАЖ АЖИЛЛААГҮЙГЭЭС ХҮНСНИЙ СҮЛЖЭЭНИЙ БҮХ ШАТАНД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

БҮЛЭГ 1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ЗОРИЛТ БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ, ХУУЛИАР ТОГТООСОН ЭРХ ЗҮЙН АКТУУДЫГ БАТЛААГҮЙ, ЗАСГИЙН ГАЗАР, ЯАМД ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийг бүрэн тусгaaгүйгээс хэрэгжилт хангалтгүй байна

Улсын Их Хурлаас хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах бодлогын баримт бичгүүдэд тусган баталжээ. Үүнд:

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал /2010 оны 48 дугаар тогтоол/
- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого /2015 оны 104 дүгээр тогтоол/
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 /2016 оны 19 дүгээр тогтоол/
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /2016 оны 45 дугаар тогтоол/
- Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /2020 оны 52 дугаар тогтоол/

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын баримт бичиг батлагдсанаар төрөөс баримтлах бодлого салбар тус бүрээр нэгдсэн нэг бодлоготой болж УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хүчингүй болж, бусад богино, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийг нийцүүлэх арга хэмжээг авах шаардлагатай болсон байна.

Үндэсний зарим хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тогтоогоогүйгээс зорилт, арга хэмжээ хэрэгжээгүй байна

Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д заасны дагуу

суурь түвшин, суурь он, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүрэх үр дүнг нарийвчлан тусгаагүйгээс үр дүнг тооцох боломжгүй байна.

Хүнсний салбарын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцыг тогтмол хугацаанд үнэлж дүгнэдэггүй, залгамж чанар, уялдаа байхгүй байгаа нь салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Засгийн газар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зарим шаардлагатай эрх зүйн актыг батлаагүй байна

Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагууд Хүнсний тухай хуульд заасан зарим журмыг батлаагүй, хувиргасан амьд организмаас гаралтай хүнсийг бүртгэх, цахим хэлбэрээр олон нийтэд мэдээлэх ажлыг хийгээгүй байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, орон тооны нарийн бичгийн даргыг томилоогүй байна

Хүнсний тухай хуулийн 18 дугаар зүйлд Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн даргаар Ерөнхий сайд, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах орон тооны нарийн бичгийн даргатай байхаар тусгасан ба зөвлөл хагас жилд нэгээс доошгүй удаа хуралдахаар нэг жилд багадаа 2 удаа хуралдаж, зөвлөмж, шийдвэр гаргах, Хүнсний тухай хуулийн 6.7, 18.5-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй боловч зөвхөн дүрмийн 3.1.5-д заасан “тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг хэлэлцэж Үндэсний зөвлөлийн зөвлөмж гаргах” чиг үүргээ л хэрэгжүүлж байна.


Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл нь хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шийдвэр гаргах, төрийн захиргааны төв байгууллагуудад зөвлөмж, чиглэл өгөх хууль, дүрмээр хүлээсэн дараах чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүнсний аюулгүй байдлыг хянахад оролцогч талуудын зарим чиг үүрэг давхардсан, хэрэгжүүлээгч байгууллагуудын ажил уялдаа холбоогүй байна

Хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллагуудын бүтцийг зургаар харуулбал:

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

**Дарга
ЕРӨНХИЙ САЙД**



Олон улсын туршлагаас үзэхэд БНСҮ, Ирланд, Япон, Тайван зэрэг дэлхийн ихэнх улсад хүнсний аюулгүй байдлыг хангах, хяналт хэрэгжүүлэх чиг үүргийг Хүнсний аюулгүй байдлын хяналтын агентлаг гүйцэтгэдэг байна.

Төрийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаа ихэнхдээ судалгаа хийх, сургалт, өдөрлөг зохион байгуулах хүрээнд хамтран ажиллаж байна.

Хүнсний аюулгүй байдал алдагдах, нийтийг хамарсан хордлого, халдвартын тохиолдол, онцгой нөхцөл байдал үүсэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, үүссэн үед хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг хууль, журмаар зохицуулж байна

Хүнсний аюулгүй байдлын ноцтой нөхцөлийн үеийн мэдээлэл солилцоог Гамшигаас хамгаалах тухай хууль болон Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалаар баталсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-аар зохицуулж, MNS:CAC/GL 19:2007 стандартын дагуу хэрэгжүүлж байна.

Монгол Улсад үйлчилж буй хууль, журам стандартад хүнсний аюулгүй байдлын олон улсын стандартад нийцсэн шаардлага, тодорхойлолтыг тусгаагүй байна. Тухайлбал:

- Үндэсний хүнсний хяналтын тогтолцооны зарчим ба удирдамж (CAC/GL 82-2013, Parts 60)-д үндэсний хүнсний хяналтын тогтолцоо нь хянах боломжгүй эрсдэлийг урьдчилан тооцох, авах арга хэмжээ үр дүнтэй эсэхийг шалгах зэрэээр хоол хүнсээр дамжих өвчин болон хүнсийн холбоотой ослын үед тандалт, мөрдөн байцаалт, хариу арга хэмжээ авахтай холбоотой хангалттай мэдээллийг цаг тухайд нь хүртээмжтэй болгоход чиглэнэ;
- Хоол хүнсээр дамжих өвчин үүсгэгч буюу Food-borne pathogens CAC/GL 77- 2011, Part2 “Хоол хүнснээс шалтгаалсан эмгэг төрөөг” эсхүл “хоол хүнсээр дамжих өвчин үүсгэгч” гэсэн тодорхойлолт

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн З дугаар зүйлийн 3.1.1-д ”хяналт шалгалт гэж иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүү/, түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолборыг” хэлнэ гэсэн тодорхойлолтыг Хүнсний болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд тусгаагүй байна.

Хүнсний салбарын мөрдөж буй зарим стандартыг шинэчлэх, шинээр батлах шаардлагатай байна

Хүнсний холбогдолтой үндэсний стандартын тоо 2020 онд 693 болж өмнөх оноос 25 буюу 3.7 хувиар өссөн бөгөөд 272 буюу 39.2 хувь нь олон улс, бус нутаг, гадаад орны стандартын түвшинд хүрсэн, 421 буюу 60.8 хувь нь уялдуулсан стандарт байна.

Монгол Улсад хүнсний технологийн 606 стандарт, 4 техникийн зохицуулалт байгаагаас 330 нь шинжилгээний арга, аргачлалтай холбоотой, 172 нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний техникийн өрөнхий шаардлагууд, 104 нь хүнсний үйлдвэрийн нийтлэг асуудал, тоног төхөөрөмж, бусад стандартууд байна.

Манай улсад шинээр боловсруулах шаардлагатай дараах 37 стандарт байна. Монгол Улсын хэмжээнд мөрдөж байгаа дараах шинжилгээний стандартуудыг шинэчлэх шаардлагатай байна. Тухайлбал:

- MNS ISO 21569 : 2011 60 х. Хүнсний бүтээгдэхүүн. Хувиргасан амьд организм, түүний гаралтай бүтээгдэхүүнийг таньж илрүүлэх шинжилгээний аргууд; Нуклейн хучлийн чанарт сууриссан аргууд;
- MNS ISO 21570 : 2013 106 х. Хүнсний бүтээгдэхүүн - Хувиргасан амьд организм-Нуклейн хучилд сууриссан тоон тодорхойлолтын арга;
- MNS ISO 21572 : 2013 21 х. Хүнсний бүтээгдэхүүн - Хувиргасан амьд организм, түүнээс гаралтай бүтээгдэхүүнийг таньж илрүүлэх шинжилгээний арга - Урагт сууриссан арга;
- MNS ISO 24276 : 2013 20 х. Хүнсний бүтээгдэхүүн - Хувиргасан амьд организм, түүний гаралтай бүтээгдэхүүнийг таньж илрүүлэх шинжилгээний арга. Ерөнхий шаардлага ба тодорхойлолт;
- MNS NY/T 448 : 2009 3 х. Хүнсний ногоон дахь органик фосфат болон карбамат пестицидиийн үлдээгдлийг тодорхойлох биологийн хурдавчилсан арга;
- MNS GB/T 5009-199 : 2009 5 х. Хүнсний ногоон дахь органик фосфат болон карбамат пестицидиийн үлдээгдлийг тодорхойлох хурдавчилсан арга;

Кодексын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй байгаагаас олон улсын хүнсний стандартыг нэвтрүүлэх ажлыг хийгээгүй байна

Хүнсний хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох чиглэлээр Олон улсын Хүнсний хууль, эрх зүйн хороог төлөөлөн ажиллах чиг үүрэг бүхий бүтэц нь Монгол Улс дахь Кодексын үндэсний зөвлөл юм.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны “Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар”-ын Хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтнээр 2015 оноос хойш

мэргэжлийн бус хүн хүн буюу 2021 оны 11 сарын байдлаар Физикч мэргэжилтэй хүн ажиллаж байгаагас шалтгаалан дээрх ажлууд үр дүнд хүрээгүй байна.

БҮЛЭГ 2. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСАН ОЛОН УЛСЫН ЧАНАРЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН ШИМ ТЭЖЭЭЛЛЭГ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР ХҮН АМЫГ ЖИГД ХҮРТЭЭМЖТЭЙ ХАНГАЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

Стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлэх журамгүйгээс зарим орон нутаг өөр өөр шийдлээр зохион байгуулж, бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалтыг хянахгүй байна

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.2.3¹, УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 4.1.3², Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хүн амын хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах зорилгоор стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлнэ”, 6.2-т “Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална” гэж заасан боловч тус журмыг баталж мөрдүүлээгүй байна.

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ хуулийн 6.2-т заасан журмын даагуу стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.”, 6.5-д “Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга авч хэрэгжүүлнэ.” гэж заасныг зарим орон нутаг хэрэгжүүлээгүй, улирлын нөөц бүрдүүлдэггүй байна.

Гол нэрийн 6 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж байгаа боловч импортын хамаарал 42.1 хувь буюу хүнсний бие даасан байдал алдагдсан хэвээрээ байна

Олон улсын практикт хүнсний хангамжийн баталгаат байдлыг “хүнсний бие даасан байдал”-ын итгэлцүүрээр, өөрөөр хэлбэл хэрэглэсэн нийт гол нэрийн бүтээгдэхүүний хэмжээнд импортын эзлэх хувийн жингэр дараах 3 түвшинд үнэлдэг байна.. Тухайлбал:

- Импорт 10.0-20.0 хувь “хүнсний бие даасан байдал” хангагдсан;
- Импорт 25.0-30.0 хувь бол “хүнсний бие даасан байдал” эрсдэлтэй;
- Импорт 40.0-хувиас илүү бол “хүнсний бие даасан байдал” алдагдсан.

Импортоор төрөл бүрийн будаа, ургамлын тос, загасыг 100.0, шувууны махны 96.5, жимс, жимсгэнийн 96.4, цөцгийн тосны 51.4, өндөгний 49, сүүн бүтээгдэхүүний 39.1, хүнсний ногооны 39.3, гурилан бүтээгдэхүүний 35.2, сахар, чихрийн зүйлсийн 34.4 хувийг тус тус хангаснаас үзэхэд манай улсын гол нэрийн 16 бүтээгдэхүүний импортын хамаарлын түвшин 42.1 хувь буюу “хүнсний бие даасан байдал” алдагдсан ангилалд байна.

Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу 2014 оноос хойш хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг гаргаж байгаа нь хүн амын хүнсний хангамж, хүртээмж, шим тэжээл, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд дүн шинжилгээ хийх, төрийн бодлого боловсруулахад ач холбогдолтой боловч зарим үзүүлэлтийг хэт өрөнхий, бодит байдлаас зэрүүтэй тооцоолж байна. Тухайлбал:

- Статистик мэдээнд улсын бүх малын дэлэн дэх сүүний нөөц хэмжээг тооцож, 1.0 сая тонн сүү гэж оруулснаас шинээн сүүний хэрэглээ 6.5 дахин их;
- Жишиг нээ хүний жилийн хэрэгцээний малын маалыг шүлснээр 157 килограмм гэж тооцсон бол, статистик мэдээнд ястай махаар тооцож оруулснаас малын маалын хэрэглээ 5.4 дахин их.

Энэ нь хүн амыг чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр жигд тогтвортой хангахад хүндрэл үүсэх, гэнэтийн хүчин зүйлсийн нөлөөнд өртөх, төрөөс баримтлах бодлого, зорилт хэрэгжихгүй байх зэрэг эрсдэлтэй тул цаашид хүнсний хангамж, хүртээмж, шим тэжээл, хүнсний аюулгүй байдлын статистик мэдээг олон улсын түвшинд нийцсэн аргачлалаар, үнэн зөв, бодитой тооцох нь чухал байна.

¹ Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана

² Стратегийн хүнсний улирлын нөөцийг эрэлт, нийлүүлэлт, хэрэглээний онцлогтой уялдуулан хувийн хэвшлийн оролцоотойгоор бүрдүүлэх

Хүнсний сүлжээний бүх үе шатны нэгдсэн бүртгэл, хяналт мэдээллийн нэгдсэн тогтолцоо байхгүй байна

Хүнсний аюулгүй байдлыг хангах, хянах чиг үүрэг бүхий яам, агентлагууд хүнсний аюулгүй байдлын талаарх цогц удирдлагын тогтолцоог бүрдүүлэхгүй тус тусдаа бие даасан үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-т “*Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална*” гэж заасныг хэрэгжүүлээгүйгээс хүнсний сүлжээний бүх үе шатны нэгдсэн бүртгэл, хяналт мэдээллийн нэгдсэн тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлж байна.

Шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх төрийн бодлогыг тодорхойлоогүй байна

Хүн амын хоол, тэжээлийн үндэсний 5 дугаар судалгаагаар 5 хүртэлх насын хүүхэдтэй өрхийн 64.9 хувьд нь хүнсний баталгаат байдал ямар нэг хэмжээгээр алдагдсан байна гэж дүгнэжээ.

Монгол Улсын хэмжээнд үндсэн шимт бодисын хүртээмж өрхийн хүнсний хэрэглээнд суурилан авч үзвэл хангалттай хэмжээнд байгаа мэт үзүүлэлттэй боловч хүнсний аюулгүй байдал, хангамж, шим тэжээлийн асуудал нь өрхийн орлого, ядуурлын түвшнээс шууд хамааралтай ба энэ талаар нарийвчилсан судалгаа, статистик үзүүлэлт байхгүй байна.

Хүнсний шим тэжээл, чанар аюулгүй байдлыг шинжилж байгаа лабораториуд өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна

Монгол Улсад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд сорил туршилт хийх чиг үүрэг бүхий төрийн болон хувийн хэвшил, их дээд сургуулиудын харьяа лаборатори 2016 онд 66 байсан бол 2019 онд 69, 2020 онд 106 болж өмнөх оноос 37 буюу 34.9 хувиар өссөн байна.

Орон нутгийн Мэргэжлийн хяналтын газрын лабораториудын одоо ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн 50 орчим хувийг 2000 оноос өмнө үйлдвэрлэсэн, элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан, засвар, шинэчлэлт хийгээгүй зэргээс шалтгаалан үйл ажиллагаа нь доголдон итгэмжлэлийн хүрээн дэх шинжилгээг бүрэн хийж чаддаггүй байна.

БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусlamжийн 20.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2013 онд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн барилгыг барьж, тоног төхөөрөмжийг бэлтгэн хүчин чадлын хувьд улсын хэмжээнд тэргүүлэх лабораторийг бий болгосон боловч нийлүүлсэн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зардал өндөр, хэрэглэх эм, урвалжийн хүрэлцээ хангалтгүйгээс 100 хувь хүчин чадлаар нь ашиглахгүй байна.

Замын Үүд, Алтанбулаг боомтын лабораторийн үйл ажиллагаа сорилт болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий стандарт шаардлагыг хангахгүй байна

Монгол Улсын хилийн боомтоор 2020 онд нийт 723.9 мянган тонн хүнс импортолсон бөгөөд 56.7 хувь нь Алтанбулаг, 41.7 хувь нь Замын-Үүд, 2.2 хувь нь бусад боомтоор нэвтэрсэн байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Замын-Үүд, Алтанбулагийн хилийн боомт, Дархан-Уул аймагт лабораторийн барилга байгууламж шинээр барих, тоног төхөөрөмжийг иж бүрнээр нь шинэчлэх төсөл 2019 оноос эхлэн хэрэгжих байгаа боловч Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын болон Хилийн мэргэжлийн хяналтын албаны лабораторийн барилгын шугам хоолойг тасалж, дэд бүтэцгүй болгосноор зориулалтын байргүй болж, үйл ажиллагаа нь доголдсон байна.

Импортоор оруулж байгаа ургамал, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний пестицидиийн үлдэгдлийг бүрэн тодорхойлох, пестицидиийн тоо хэмжээ, нэр төрөл, хэрэглээнд хяналт тавих, гарал үүслийг мөрдөн мөшгөх тогтолцоо хангалтгүй байна

Газар тариалангийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэхэд ургамал хамгаалал онцгой үүрэгтэй бөгөөд түүнийг хэрэгжүүлэхдээ ургамал хамгааллын химийн бодис буюу “пестицид”-ийг импортоор авч ашиглаж байна.

Манай улсад пестицидийн тоо хэмжээ, нэр төрөл, хэрэглээнд хяналт тавих, гарал үүслийг мөрдөн мөшгөх тогтолцоо хангалттай ажиллаж чадахгүй байна.

Одоогийн тогтолцоогоор ХХААХҮЯ эрдэс бордоо, пестицид импортлох тусгай зөвшөөрлийг олгож, хилийн боомт дээр ХМХА хянан, хилээр оруулах зөвшөөрөл олгож, хэрэглээнд МХЕГ хяналт тавьж, хорио цээрийн асуудлыг Хилийн хорио цээрийн алба хариуцаж байгаа боловч импортын эрдэс бордоо, пестицидыг хилийн боомт болон гүний лабораторид нарийн шинжилдэггүй бичиг баримтыг шалгах, хянах ажлыг хийдэг боловч чанаарын хяналт хийдэггүй байна.

Ургамлын хорио цээрийн лабораторийн шинжилгээнд ашиглах орчин үеийн аргазүй, өвчин, хортон шавжийг зүйлийн түвшинд тодорхойлох аргачлал, багаж төхөөрөмж дутагдалтай байгаагаас шалтгаалан зарим дээжид илэрсэн шавжийг тодорхойлж чадахгүй байна

Замын-Үүд хилийн боомтын ХМХА-ны ургамлын хорио цээрийн лаборатори нь импортоор орж ирж буй төмс, төрөл бүрийн хүнсний ногоо, жимс жимсгэнэ, цагаан будаа, чимэглэлийн цэцэг зэрэг ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд гадаад болон дотоод хорио цээртэй хортон шавж, хачиг, өвчин, хог ургамлаар бохирдсон эсэхийг шинжилдэг бөгөөд 2020 онд 21129 дээжнээс 72, 2021 оны эхний хагас жилийн байдлаар 22328 дээжнээс 63 дээжид ургамлын дотоод хорио цээртэй зүйл илэрсэн байна.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын горим зөрчигдсөнөөс үүсдэг микотоксины хувьд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори олон улсын түвшинд нийцсэн арга, аргачлал, тоног төхөөрөмжөөр шинжилдэг бөгөөд орон нутгийн мэргэжлийн хяналтын лабораториудад багаж, тоног төхөөрөмж байдаг боловч эм, урвалжийн төсөв хүрэлцдэггүйгээс шинжилдэггүй байна.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд хүнд металлын үлдэгдлийг зөвхөн Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори атом шингээлтийн спектрометрийн багажаар шинжилж, бусад лабораториудад багажгүй тул шинжилдэггүй байна

Сав, баглаа боодол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээ, илэрч буй зөрчил буурахгүй байна

Хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэх талаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлийн 3.4.2.6, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйл, Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4 дүгээр зүйлийн 4.1.10-т тус тус заасан байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтын дунд илэрч буй сав, баглаа боодол, хаяг шошготой холбогдолтой зөрчлийн тоо жилээс жилд өсөж байгаа нь зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээ буурахгүй байгааг харуулж байна

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс 2018 онд 829 өрхийг хамруулан хийсэн судалгаагаар хотод 78.1 хувь, хөдөөд 50.4 хувь нь тосны болон химиийн бодис хадгалах зориулалт бүхий хуванцар сав хэрэглэдэг дун гарсан байна.

Нийгэм, олон нийтийн дунд хуванцар сав, баглаа боодлын хэрэглээ улам нэмэгдэх болсон бөгөөд аудитын явцад Монголын социологичдын холбооноос хийсэн судалгаанд оролцогчдын 50 хувь нь доорх нийлэг бүтээгдэхүүнийг хүнсэндээ хэрэглэж байгаагаас хуванцар сав (хүнсний болон хүнсний бус), бүх төрлийн гялгар уутны хэрэглээ хамгийн өндөр байна.

Хоол, хүнсний талаарх хүн амын мэдлэг боловсролыг дээшилүүлэх сургалт, сурталчилгааны ажлын үр дүнг тооцдоггүй, үнэлж дүгнэдэггүй, хэрэгжилт хангалтгүй байна

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.1.3-т “Хүн амын дунд хоол тэжээлийн зохицтой хэрэглээг төлөөшиүүлж, зонхилох халдварт бус өвчнөөс сэргийлэн бичил тэжээлийн дутлыг бууруулна” гэж заасан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, Эрүүл мэнд, Боловсрол, шинжлэх ухааны яамд харилцан уялдаа холбоогүй ажилласнаас хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсрол олгох ажил үр дүнгүй, хяналтгүй хэрэгжиж, иргэдийн хоол тэжээлийн гаралтай өвчлөл буурахгүй байна.

ХХААХҮЯ, ЭМЯ, МХЕГ, НЭМҮТ зэрэг газруудаас жил бүр олон нийтийг соён гэгээрүүлэх, хүнсний мэдлэг боловсрол олгох сургалт сурталчилгааны ажлыг хийдэг боловч үр дүнг тооцдоггүй, иргэдийн хоол тэжээлийн талаар мэдлэг боловсрол дээшилсэн эсэхийг үнэлж дүгнэдэггүй нийтлэг зөрчил илэрч байна.

НҮБ-ийн хүүхдийн сангийн санхүүжилтээр НЭМҮТ-өөс “Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн тулгамдаж буй асуудлууд” сэдвээр хийсэн судалгаагаар иргэдийн хоол тэжээлийн зөв зохистой хэрэглээг сайжруулах, таниулах ажлыг зохион байгуулах шаардлагатай талаар зөвлөсөн хэдий ч зөвлөмжийн дагуу мэдлэг боловсрол олгох ажил төдийлөн хийдэггүй байна.

БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ ТАВЬДАГГҮЙ, ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮНГ ТООЦДОГГҮЙ, ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ САНХҮҮЖИЛТИЙГ ШИЙДВЭРЛЭЭГҮЙ БАЙНА.

Үндэсний хөтөлбөрүүдийг батлахдаа санхүүжилтийн эх үүсвэрийг нарийвчлан тусгaaгүй, төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг Төсвийн тухай хуулиар баталж хэрэгжүүлдэггүй байна

Үндэсний хөтөлбөрийг батлахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн /хуучин/ 18.1-д “Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна” гэж заасны дагуу шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг нарийвчлан төлөвлөөгүйгээс хөтөлбөр бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэхгүй байна.

ХХААХҮЯ-аас жил бүр улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөрүүдийг үндэслэн, Төсвийн тухай хуульд заасны дагуу хөдөө аж ахуйг сайжруулах, хүнсний сүлжээний үе шатуудад дэмжлэг үзүүлэх чиглэлээр төсөл, арга хэмжээнд шаардагдах төсвийг төлөвлөсөн боловч тухайн жилийн төсвийн тухай хуульд 70 орчим хувийг нь батлаагүй байна.

Төсвийн тухай хуульд нэн чухал, хэрэгцээ шаардлагатай арга хэмжээнд хөрөнгө баталдаггүйгээс гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж байна

Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн байдлын өнөөгийн байдлыг бодитоор судалж, нөхцөл байдлыг тодорхойлдог “Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн байдал”-ын судалгааг Хүнсний тухай хуулийн 9.1³, 9.1.1⁴-т заасны дагуу ЭМЯ, НЭМҮТ-өөс 5 жил тутамд хийх чиг үүрэгтэй боловч тус судалгааны санхүүжилтийг НҮБ-ийн хүүхдийн сангаас, “Халдварт бус өвчин, осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тогтоох үндэсний шаталсан судалгаа”-г Эрүүл мэндийг дэмжих сангаас тус тус санхүүжүүлсэн байна.

Хуульд заасан журмыг баталж мөрдөөгүй, хэрэгжүүлээгүй байна

Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйл 8.5-д “Энэ хуулийн 8.1, 8.3-д заасан хүнсний үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, урамшууллын хэлбэр, тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална”, Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6-д “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулалт олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмыг тариалангийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасныг үндэслэн стратегийн хүнсний урамшууллыг олгодог байна.

Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйл 8.5-д -д заасан журмыг баталж хэрэгжүүлэхгүйгээр Засгийн газрын тогтоолд үндэслэн нөөцийн махны урамшууллыг олгож байна.

Баталсан төсвийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулж, зарцуулсан хөрөнгийн үр дүнг үнэлж дүгнэдэггүй байна

Салбарын яамнаас жил бүр тариаланчдыг дэмжих, ард иргэдийг эрүүл шинэ ургацын хүнсний ногоогоор хангах зорилгоор “Намрын ногоон өдрүүд” арга хэмжээг зохион байгуулж 2018-2019 онд нийт 59.2 сая төгрөгийг, 2021 онд 39.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан боловч тус арга хэмжээний үр дүнг үнэлж дүгнэдэггүй байна.

³ 9.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

⁴ 9.1.1.хүн амын хоол тэжээлийн үндэсний хэмжээний судалгааг таван жил тутамд гаргаж, дүнг холбогдох төрийн байгууллага болон нийтэд мэдээлэх;

ХХААХҮЯ-аас Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Хүнсний аюулгүй байдлын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, үндэсний үйлдвэрлэл, экспорт, импорт, хүн амын хүнсний хэрэглээний нэгдсэн мэдээллийн сан, сүлжээ бий болгох, хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлттэй зорилгоор 2018 онд 75.0 сая төгрөгийн санхүүжилтийг төлөвлөж, 71.4 сая төгрөгийг зарцуулсан боловч 2019 оноос хойш одоогоор хэрэглэгдэж буй нэгдсэн сан байхгүй, төсвийн зарцуулалтын үр дүнг үнэлж дүгнээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан дараах тоног төхөөрөмжийг ашиглахгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна. Үүнд:

- Архангай аймгийн Цахир,Өндөр-Улаан, Их тамир суманд “Сум дундын түүхий эд бүтээгдэхүүний чанарын лаборатори”-ийн тоног төхөөрөмжийг 2020 онд бэлтгэн нийлүүлж ашиглалтад оруулсан боловч ашиглалт, бүртгэлд тавих хяналт хангалтгүй байна.
- “Монгол мал” ундэсний хөтөлбөрийн 3.3.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг эхлүүлэх, мал эмнэлгийн үлчилгээг сайжруулах зорилгоор Увс аймагт 2018 онд 142.1 сая төгрөгийн 12 ширхэг, 2019 онд 74.1 сая төгрөгийн 5 ширхэг мал угаалгын зөөврийн тоног төхөөрөмжийг ХХААХҮЯ-аас хүргүүлсэн боловч зөөврийн мал угаалгын ванн нь зөөврөлхөд авто машины замаас өргөн, малыг нэг бүрчлэн өргөж хийдээ зэрэгээс шалтгаалан ашиглах боломжгүй тул аймгийн Хүнс, аж ахуй газар болон сумдын ЗДТГ-ын аж ахуйн хашаанд хадгалаадж байна.
- Хэнтий аймагт “Хэнтий брэнд” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд 7.3 сая төгрөгийн тарааг, цөцийн савлагч машин, 7.3 сая төгрөгийн шингэн зүйл савлагч, 9.4 сая төгрөгийн хуванцар сав үлээгч машин, нийт 24.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан боловч аймгийн ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй, одоогоор ашиглаагүй байна.
- Завхан аймагт Малын эрүүл мэнд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Улиастай сумын ОНХС-аас мал эмнэлгийн хувийн лаборатори байгуулна гэж 8.0 сая төгрөг зарцуулсан боловч нийлүүлсэн тоног төхөөрөмж нь орчин үеийн хэрэгцээ шаардлаад нийцээгүйээс одоо болтол зориулалтаар нь ашиглаагүй байгаа тул нийлүүлэгч этгээд ашиг сонирхлын зөрчил үүсэсэн байх магадлалтай ээж Завхан аймаг дахь ТАБ-аас үзэж хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтгүйгээс үр ашиггүй хөрөнгө оруулалт хийж, төслийн үр дүнг бууруулж байна. Тухайлбал:

- Дэлхийн банкнаас “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийг 2020 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хуртмалх хугацаанд хэрэгжүүлэхээс 2021 оны 9 дүэээр сарын 15-ны өдрийн байдлаар нийт 15.8 сая ам.доллар буюу 45.0 тэрбум төгрөгийн татам авч, 38.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Зээлийн эргэн төлөлт 2025 оноос эхлэх бөгөөд зээлийн хүү 1.65 хувь байна. Гэтэл тус төслийн хүрээнд нийт 45 мянган гаруй малчин өрхөд малын хүчтэй тэжээлийн тусламж үзүүлж, 179849 малчин өрхөд тус бүр 100.0 мянган төгрөг нийт 17,984.9 сая төгрөгийг буцалтгүй тусламжкаар олгосон нь үр дүнгүй санхүүжилт болсон байна.
- Азийн хөгжлийн банкны “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд /2016-2022 он/ Замын-Үүд, Алтанбулаг хилийн боомтуудад 5,081.0 сая төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодис, тавилга эд хогшлыг Дархан-Уул аймгийн МХГ, Алтанбулаг боомт дах XMXA, Замын-Үүд боомт дах XMXA-д хулээгээн өгсөн хэдий ч 5,530.0 сая төгрөгөөр лабораторийн барилга барихаар төлөвлөсөн барилгын ажлын явц 35-60 хувийн гүйцэтгэлтэй байгаа тул дээр дурдсан хөрөнгийн ашиглах боломжгүй, барилга байгууламж ашиглалтад орохоос өмнө өдгөөр хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусаж чанаргүй хөрөнгө оруулалт болох эрсдэлтэй байна.
- Завхан аймагт Хүн амын хоол тэжээл хөтөлбөрөөр 2018-2020 онд НҮБ-ын Хүүхдийн сангаас амин дэм, олон наирлагат бичил тэжээлийн бэлдмэл, шинээн сэлбэж давсны усмыалын үлдээгээд, захиалга, зарцуулалтад аймгийн ЭМГ-аас тавих хяналт хангалтгүйгээс 356.4 сая төгрөгийн өртөгтэй 46,256 хайрцааг олон наирлагат бичил тэжээлийн бэлдмэлийн хугацаа дуусан устгасан байна

Сум, орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих зорилгоор 2018-2020 онд олгосон санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил түгээмэл байгаа нь салбарын яамнаас “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.1.4-т⁵ заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй, тус сангийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна. Тухайлбал:

- Говь-Алтай аймагт 2018-2020 онд 153 иргэн, ААНБ-д 1,025.5 сая төгрөгийн зээлийг олгосноос нийт зээлдэгчдийн 8 хувь буюу 22 иргэн, ААН 80.9 сая төгрөгийн зээлийг гэрээт хугацаандадаа төлөөгүй байна.
- Дорноговь аймагт 2017-2020 онд нийт 81 иргэн, ААНБ-д 1,127.0 сая төгрөгийн зээлийг олгосноос 21 зээлдэгч үйл ажиллагаа явуулаагүй, 5 зээлдэгч зээлийг зориулалт бусаар ашигласан байна.
- Дундговь аймагт 2019-2021 оны хугацаанд нийт 554.8 сая төгрөгийг мах ангилалын дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр олгосон ба эдэгэр нь махны үйлдвэрлэл эрхлэх бус малчдаас мал авч дамжуулан борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг байна. Мөн аудитын явцад зээлдэгчдийн үйл ажиллагаатай танилцахад 3 зээлдэгч зээлийг зориулалт бусаар ашигласан зөрчил илэрсэн байна.
- Хоёд аймагт 2015-2020 онуудад хүнс, хөнгөн үйлдвэр, газар тариалан, сүү цагаан идээ, сүүний чиглэлээр 266 иргэн, аж ахуйн нээгжид 1,300.8 сая төгрөгийн төгрөгийн зээл олгож, үүнээс 122 иргэн, аж ахуйн нээгжийн 483.1 сая төгрөгийн зээл зориулалт бусаар зарцуулсан байна.

⁵ 3.1.4. сангаас олгосон зээлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн хөтөлж, холбогдох мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд оруулах;

Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-д⁶ заасан иргэдэд тус хуулийн 22 дугаар зүйлд заасан хүнс тэжээлийн дэмжлэг, хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийг Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоолоор баталсан “Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам”-ын 2.3-т⁷ заасны дагуу Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд /хуучин нэрээр/, Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын /хуучин нэрээр/ даргын хамтарсан тушаалаар 2010, 2013, 2017 онуудад шинэчлэн баталсан “Орлогыг орлуулан тооцох аргачлал”-аар 2017 онд хийсэн өрхийн амьжирааны түвшнийг тодорхойлох судалгааг үндэслэн хүнсний эрхийн бичиг олгох тушаал, журмын дагуу⁸ олгож байна.

Хүнсний эрхийн бичигт 2021 оны 7 дугаар сарын байдлаар хамрагдсан нийт иргэдийн дундаж нас 30, хамгийн өндөр нас 106 байсан бөгөөд нийт иргэдийн 47.7 хувь нь хөдөлмөрийн насны буюу 18-60 насны иргэд эзэлж байгаа бөгөөд эдгээр иргэдийн дийлэнх нь буюу 66.9 хувь нь орон нутагт амьдарч байна.

Цаашид “Орлогыг орлуулан тооцох аргачлал”-ыг холбогдох журамд заасны дагуу шинэчлэн баталж, өрхийн амьжирааны түвшнийг тодорхойлох аргачлалыг жил тутам тогтмол шинэчилж байх, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.9-д “Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ” гэж тусгасан зорилтын хүрээнд хүнсний эрхийн бичиг авч буй хөдөлмөрийн насны иргэдийн өрхийн амьжирааг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, ингэснээр сар бүр улсын төсвөөс хэмнэх боломжтой байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглувулсан нотлох зүйл, аудитын дунд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, урт болон дунд хугацааны хөгжлийн баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүдэд зорилт, арга хэмжээг хэсэгчлэн тусгасан боловч шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшнийг оновчтой тодорхойлоогүйгээс зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, үр дунд хүрээгүй байна.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн болон Эрүүл мэндийн яам хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлээгүйгээс хүнсний хангамж, хүртээмж, хүнсний чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдэлийг үнэлэх журмыг боловсруулаагүй, баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг улсын бүртгэлд бүртгээгүй, нэгдсэн мэдээллийн санг үүсгээгүй байна.
- Хүнсний аюулгүй байдлын зөвлөл жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоох ажлаар үйл ажиллагаагаа хязгаарлан хуулиар тодорхойлсон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлдэггүйгээс хүнсний аюулгүй байдлыг хангах төрөөс баримтлах бодлого, хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.
- Мал эмнэлгийн ерөнхий газар болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газар мал эмнэлгийн салбарын хяналтыг давхардуулан гүйцэтгэж байгаа нь малчид, худалдаачид, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдэд хүндрэл учруулж, хоорондоо харилцан зөрчилтэй эрх зүйн актыг гаргаж байна.
- Хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүс дэх хяналт шалгалт хийх, ижил чиг үүргийн давхардсан бүртгэл хөтлөх үйл ажиллагаа нь бараа, хүнсний бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэхэд төрийн үйлчилгээний шат дамжлагыг нэмэгдүүлж, үйлчилүүлэгчдэд чирэгдэл учруулсан хэвээр байна.
- Монгол Улс дахь Кодексын үндэсний зөвлөл нь орон тооны бус, тогтвортой үйл ажиллагаа явуулахгүй байгаагаас олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг хийхгүй байна.
- Хүнсний тухай хуульд заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газраас баталж, мөрдүүлээгүйгээс зарим аймаг, нийслэл хүнсний нөөцийг хангалттай бүрдүүлээгүй, нөөцийн сэлгэлт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, давагдашгүй хүчин зүйл үссэн тохиолдолд хүнсний хомсдол үүсэж, үнийн өсөлт бий болох эрсдэлтэй байна.
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн төрийн бодлого, зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүйгээс хүрэх түвшнийг хангаагүй, хүнсний бие даасан байдал алдагдсан хэвээрээ байна.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам “Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журам”-ыг баталж, мөрдүүлээгүй нь хүнсний сүлжээний бүх үе шатны нэгдсэн бүртгэл, хяналт мэдээллийн нэгдсэн тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлж байна.

⁶ 3.1.2-т “нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн” гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжирааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журам

⁷ Өрхийн амьжирааны түвшин тодорхойлох аргачлалыг 3 жил тутамд шинэчилнэ

⁸ Өрхийн амьжирааны түвшин доогуур айл өрхийн 0-16 хүртэлх насны гишүүнд 8,000 төгрөг, 16-аас дээш насны гишүүнд 16,000 төгрөгийн хүнсний эрхийн бичиг авах

- Хүнсний аюулгүй байдлын зарим статистик үзүүлэлтийг бодит байдлаас зөрүүтэй тооцоолж байгаагаас тус тоо мэдээллийг ашиглан төрөөс олгох дэмжлэг, урамшуулал болон бусад шийдвэр, бодлого, төлөвлөлт алдаатай гарах эрсдэлтэй байна.
- Улс, орон нутгийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, ургал болон их засвар, үйлчилгээг хийдэггүй, эм, урвалжийн төсөв хангалтгүй, хүнсний шим тэжээл, чанар, аюулгүй байдалд хийж буй шинжилгээ өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй, лабораториудыг нэгдсэн удирдлагаар хангаж чадахгүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон өндөр хүчин чадалтай лабораторийг ашиглахгүй байна.
- Хоол, хүнсний талаарх хүн амын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлын үр дүнг тооцдоггүй, хэрэгжилт хангалтгүй байгаагаас хоол боловсруулах тогтолцооны болон ходоодны хорт хавдрын өвчлөл буурахгүй байна.
- Хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үндэсний хөтөлбөрийг батлахдаа санхүүжилтийн эх үүсвэрийг нарийвчлан тусгадаггүйгээс хэрэгжих боломжгүй, нэн шаардлагатай зарим ажлын санхүүжилтийг гадаадын зээл, тусламжаар шийдвэрлэж, төсөл, хөтөлбөрийн үр дүнг тооцдоггүй, хяналт хангалтгүйгээс хөрөнгийг үр ашигтүй, зориулалт бусаар зарцуулсан байна.
- Төрөөс олгож буй хүнсний эрхийн бичгийн халамжийн үйлчилгээ авах иргэдийг оновчтой зөв сонгох шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тус зөвлөлийн тайланг тогтсон хугацаанд авч хэлэлцэн, үр дүнг тооцож байхад анхаарлаа хандуулах.

Монгол Улсын Засгийн газарт:

- Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хүнсний аюулгүй байдлыг хангах богино, дунд, урт хугацааны бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох;
- Засгийн газар болон яам, агентлагууд хууль, журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээг авч, хариуцсан ажилдаа хайхрамжгүй хандсан, үүргээ биелүүлээгүй эрх бүхий албан тушаалтуудад хариуцлага тооцон ажиллах;
- Төрийн холбогдох байгууллагуудын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, үйл ажиллагааны уялдаа холбоо, эрх зүйн орчныг сайжруулах;
- Хүнсний тухай хуулиар үүрэг болгосон “Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах, хянах журам”, “Стратегийн хүнсний үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг урамшуулал, тэдгээрийг олгох журам”-ыг боловсруулж, хэрэгжилтийг ханган, хүнсний аюулгүй байдлын нэгдсэн мэдээллийн санг бий болгох, хүнсний хангамж, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг сайжруулах.

Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн даргад:

- Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад:

- Засгийн газрын тогтооолоор баталсан хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн зорилт, үр дүнд үнэлгээ хийж, УИХ болон олон нийтэд танилцуулах;
- Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх журмыг батлан мөрдүүлж, хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах;
- Кодексын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, Олон улсын хууль, эрх зүйн хорооноос гаргасан стандарт, удирдамж, зөвлөмжид нийцүүлэн манай улсад мөрдөж байгаа зарим стандартыг шинэчлэх, хуульд тусгаагүй чухал ач холбогдолтой нэр томьёо, тодорхойлолтыг хуульд нэмж тусгах;
- Улсын хэмжээний хүнсний хангамж, нийлүүлэлтийн тоон үзүүлэлтийг үйлдвэрлэл болон худалдааны нийт тоо хэмжээнд сууринж илүү нарийвчлан бодит мэдээг гаргах;
- Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг боловсруулж батлан мөрдүүлэх;
- Малын эрүүл мэнд болон Малын эмийн нэгдсэн бүртгэл, хяналтын системийг уялдуулж, боловсронгуй болгох;

- Хүнсний чанар, аюулгүй байдлыг шинжилж байгаа лабораториудын бүртгэлийн системийн уялдааг хангаж, хяналтын нэгдсэн мэдээллийн санг үүсгэх төрийн холбогдох бусад байгууллагын системтэй уялдуулах;
- Хүн амын хоол тэжээлийн талаар мэдлэг боловсрол олгох талаар цогц ажлыг зохион байгуулж, үр дүнг үнэлж тооцох;
- Үндэсний хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ шаардагдах төсвийг эх үүсвэрээр нарийвчлан төлөвлөж батлуулах, тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг Төсвийн тухай хуульд тусгаж, зарцуулалтад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах.

Боловсрол, шинжлэх ухааны сайдад:

- ШУТИС-ийн харьяа Үйлдвэрлэл технологийн сургуулийн Хүнсний судалгаа, инновацын нээлттэй төвийн үйл ажиллагааг Хүнсний аюулгүй байдал үндэсний лавлагаа лабораторитой уялдуулж, хүчин чадлыг бүрэн ашиглах;
- Хүн амын хоол тэжээлийн талаар мэдлэг боловсрол олгох талаар цогц ажлыг зохион байгуулж, үр дүнг үнэлж тооцох.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад:

- “Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам”-д заасны дагуу өрхийн амьжирааны түвшнийг тодорхойлох орлогыг орлуулан тооцох аргачлалыг 3 жил тутамд шинэчлэх, мэдээллийн санг шинэчлэх, хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй хөдөлмөрийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.

Эрүүл мэндийн сайдад:

- Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх журмыг батлан мөрдүүлж, хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах;
- Хүн амын хоол тэжээлийн талаар мэдлэг боловсрол олгох талаар цогц ажлыг зохион байгуулж, үр дүнг үнэлж тооцох.

Үндэсний статистикийн хороонд:

- Хүнсний хангамж, хүртээмж, шим тэжээл, хүнсний аюулгүй байдлын статистик мэдээг олон улсын түвшинд нийцсэн аргачлалаар, үнэн зөв, бодитой тооцох.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт:

- Итгэмжлэлийн гэрчилгээний хугацаа дууссан төрийн болон хувийн хэвшлийн лабораториудын зөрчлийг арилган, лабораторийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, хүний нөөц, урвалж бодисыг шууд өртөг зардалтай нь уялдуулсан үнэ тарифын зохицуулалт хийж, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээг хугацаанд нь хийх, урсгал зардлаа өөрөө санхүүжүүлэх бололцоог бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг бүрэн хангахуйц шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

- Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ хуулийн 6.2-т заасан журмын дагуу стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ”, 6.5-т “Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга авч хэрэгжүүлнэ” гэж заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах;
- Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, зорилтыг хангах зорилгоор хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах.

Баталгаажуулалт

Чанарын хяналт хийсэн:

Аудитын гуравдугаар газрын захирал,
тэргүүлэх аудитор

Д.Энхболд

Хянасан:

Аудитын менежер

Б.Долгорсүрэн

Тайлангийн хураангуйг бэлтгэсэн:

Аудитор

Ж.Мөнхбилгүүн